



Эрдэнэ Ресурс нь 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, 2019 оны Хөндий Алтны Төслийн төлөвлөгөөг танилцууллаа

Канад улс, Нова Скошиа муж, Халифакс хот – 2019 оны 4-р сарын 1

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь 2018 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Хөндий Алтны Төслийн ажлын явц болон цаашдын төлөвлөгөөг танилцуулахад таатай байна. Компанийн SEDAR (“System for electronic document analysis and retrieval”)–д бүртгэгдсэн 2018 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан (“MD&A” буюу “Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ”) ба жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэл (“AIF” буюу “Annual Information Form”) нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй нэг хэсэг болно.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Бид голлох судалгаануудыг хийн, Хөндий Алтны Төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг авснаар жилд хамгийн багадаа 50,000 унц олборлох хүчин чадал бүхий өндөр агуулгатай ил уурхайг хөгжүүлэлтийн шатанд хүргэх, цаашид олборлолтын хэмжээг 100,000 унц хүргэх боломжийг нэмэлт хайгуул, худалдан авалт хийх замаар нэмэгдүүлэхэд зорин ажиллаж байна. Өнгөрсөн нэг жил нь бидний хувьд өндөр үр бүтээлтэй жил болж өнгөрлөө. 2018 оны 9 сард Хөндий Алтны Төслийн анхан шатны нөөцийн тайлан, 12 сард анхан шатны эдийн засгийн тооцооллыг (“PEA”) танилцуулж, энэхүү төсөл нь олборлолтын явцад эдийн засгийн хувьд үр ашигтай, хөгжүүлэлтийн шатны эрсдэл бага бөгөөд цаашид Хөндий Алтны Дүүргийн суурь болох боломжтой төсөл хэмээн үзэж байна.

Мөн Хөндий Алтны Төслийн Урьдчилсан ТЭЗҮ (“PFS”) боловсруулах компанийг сонгон, олон улсын инженерчлэлийн компани болох Tetra-Tech, Inc.-тэй хамтран ажиллах гэрээг байгууллаа. Хөгжүүлэлтийн дараагийн шатанд ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдлийг гаргаад байна. Бид 2019 оны 4-р сард Хөндий Алтны Дүүрэгт хэтийн төлөв бүхий талбайд хайгуул хийх, Урьдчилсан ТЭЗҮ-г дэмжих өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлэхээр төлөвлөсөн. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд Эрдэнэ Ресурс хоёр өндөр агуулга бүхий алтны ордуудыг нээн илрүүлээд байна. Эдгээр ордууд маань урьд өмнө нь системчилсэн геологийн хайгуул хийгдэж байгаагүй бүсэд илэрсэн нь цаашид энэхүү бүс нутагт шинэ нээлтүүд гарах өндөр магадлалтайг илтгэнэ.” хэмээв.

2018 оны төслийн болон санхүүгийн онцлох мэдээлэл ба үйл явдлууд

Хөндий Алтны Төсөл – Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшил

- National Instrument 43-101 (“NI 43-101”) нөөц тайлагнах тайлагналын стандартын дагуу боловсруулсан Урьдчилсан эдийн засгийн тооцооллыг 2018 оны 12-р сард танилцуулсан:

- Татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалтаар буюу “NPV_{5%}”) болон өгөөжийн дотоод хувь (“IRR”) нь тус бүр \$99 сая ам.доллар болон 56% хэмээн тооцоологдсон. (алтны үнийг \$1,200/унц-аар төсөөлөхөд)
- Татварын өмнөх өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хоргодуулалтаар буюу “NPV_{5%}”) болон өгөөжийн дотоод хувь (“IRR”) нь тус бүр \$135 сая ам.доллар болон 70% гэж тооцоологдсон.
- Анхны хөрөнгө оруулалт: \$32 сая ам.доллар , гэрээт олборлогчийн нөхцөлөөр
- Нэг унц алт үйлдвэрлэх нийт зардал (“AISC”) нь \$714 ам.доллар
- Ашиглалтын хүдрийн дундаж агуулга 3.42 г/т
- Жилд олборлох алтны дундаж хэмжээ 51,200 унц
- Уурхайн ашиглалтын хугацаа 8 жил, уурхай байгуулах 1 жил болон хаалтын хугацааны 2 жил багтаагүй
- Эргэн төлөгдөх хугацаа 1.8 жил
- Төслийн анхан шатны нөөцийн тайланд тусгаснаар:
 - 0.7 г/т захын агуулгаар: 2.3 г/т алтны дундаж агуулга бүхий 751,000 унц алтны бодит нөөц, 1.8 г/т алтны дундаж агуулга бүхий 291,000 унц алтны боломжит нөөц тогтоогдсон.
 - 1.4 г/т захын агуулгаар: 3.7 г/т алтны дундаж агуулга бүхий 642,000 унц алтны бодит нөөц, 2.3 г/т алтны дундаж агуулга бүхий 250,000 унц алтны боломжит нөөц тогтоогдсон.
- Анхан шатны нөөцийг боловсруулахад Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд 4,900 метрийн өрөмдлөг хийсэн:
 - Хойд Мидфийлд бүсийн алтны хүдэржилтийг хойд зүгт тэлж, BKD-254 өрмийн цооногт 2.6 г/т алтны дундаж агуулга бүхий 81.4 метр зузаантай интервал илэрсэн ба үүнээс 17 метр нь 9.2 г/т алтны агуулгатай байна.
- Орон нутгийн оролцоог амжилттай хэрэгжүүлж буй талаар хөндлөнгийн байгууллагаас эерэг үнэлгээ авсан:
 - Бритиш Колумбын Их Сургуулийн судлаачид нь Эрдэнэ Ресурсийн уурхайн өмнөх үе шатанд орон нутгийн хамтын ажиллагаа, оролцоо нь үнэ цэнийг бий болгон, шилдэг туршлага болж буйг танилцуулсан. (Тайлантай [эндээс](#) танилцана уу.)

Бүс нутгийн хайгуул

- Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд орших Алтан Сум, Хойд Хөндий талбайд 7 хэтийн төлөвт бүсийг шалгах 3,452 метрийн 25 өрмийн судалгааг хийсэн.
 - Алтан Сумд хийсэн нийт өрмийн 70% нь алтны эрдэсжилт бүхий гажилтыг огтолсон (>0.1 г/т алтны агуулгатай), үүнээс гуравт нь 20 г/т алтны агуулга бүхий 1-2 метрийн интервал илэрсэн.
 - Алтан Сумийн структурыг баруун зүгт 500 метрээр тэлж, гол структураас өмнө зүгт 400 метрт алтны эрдэсжилт бүхий гажилттай 1.2 км-ийн тренд (суналын дагуу нээлттэй) байгааг тогтоосон.
- Компанийн 51%-ийн эзэмшлийн Улаан тусгай зөвшөөрлийн талбайд анхан шатны хайгуулын өрөмдлөг хийсэн бөгөөд тусгай зөвшөөрлийн төв хэсэгт 1.3 км талбайд 1,050 метрийн 3 цооног өрөмдсөн:

- Галт уулын чулуулагт байх хэсэгчлэн орших, зэсийн ахиу агуулгатай кварц-пиритийн зэрэгцээгээс штокверк судлуудыг огтолсон ба мөн газрын гадарга дээрх пропицитийн хувирлаас газрын гүн дэх филлик (кварц-серицит-пирит) хувирлын тодорхой ялгагдах бүсчлэлийг огтолсон.
- Монгол улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, 22 хэтийн төлөвтэй талбайг тодорхойлсон бөгөөд энэхүү судалгаанд тулгуурлан тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөж байна:
 - Монгол улсын баруун өмнөд хэсэгт сүүлийн 10 жилийн хугацаанд анх удаа зарласан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцсон.

Санхүүгийн гүйцэтгэл – жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хураангуй

- 2018 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон санхүүгийн жилд Компани нь \$3,656,990 канад долларын цэвэр алдагдалтай буюу нэгж хувьцаанд ногдох алдагдал \$0.02 канад доллар гарсан. Энэ нь 2017 оны үзүүлэлт буюу \$4,027,465 канад долларын алдагдал буюу нэгж хувьцаанд ногдох алдагдал \$0.03-тай харьцуулахад алдагдал буурсан үзүүлэлт юм.
- Капиталжуулсан зардлыг оролцуулсан хайгуулын зардал нь 2018 онд \$5,958,692 гарсан бөгөөд 2017 оны \$10,244,775-тай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Энэ нь 2018 онд Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн NI 43-101 Анхан шатны эдийн засгийн тооцоолол болон нөөцийн тайланг боловсруулахад төвлөрөн ажилласнаас шалтгаалсан.
- 2018 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд Компанийн Захиргаа, удирдлагын зардал (мөнгөн бус, хувьцаанд суурилсан нөхөн төлбөр болон элэгдлийг оролцуулахгүй) \$1,401,342 гарсан нь 2017 оны \$1,495,106-тай харьцуулахад үнэмлэхүй зөрүүгүй байна.

Санхүүгийн байдал болон санхүүжилт

- 2018 оны 6-р сард Монголын Хөрөнгийн Биржид давхар бүртгүүлсэн анхны компани болсон:
 - Хөрөнгө оруулагчдын бүртгэлд 6,000 Монгол хөрөнгө оруулагчдыг нэмсэн.
 - Бүртгэл хийгдсэний дараа Монгол улсад 1,500,000 хувьцаа арилжаалагдаад байна.
 - Эрдэнэ Ресурс нь давхар бүртгэл хийгдэхтэй зэрэгцэн хаалттай санхүүжилт хийн, 4.12 сая канад долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн.
- Компани нь 2019 оны 2-р сард Урьдчилсан ТЭЗҮ, тусгай зөвшөөрлүүд, хайгуул болон бусад ажлыг санхүүжүүлэх зорилгоор \$2.53 сая долларын хөрөнгө оруулалт татсан:
 - Эрдэнэ Ресурс нь одоогийн байдлаар \$3.20 сая долларын эргэлтийн хөрөнгөтэй байна.
- 2019 оны 3-р сарын 26-нд Эрдэнэ Ресурс нь Сэндсторм Гоулд (“Sandstorm Gold Limited”) компанид борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийн 50%-ийг буцаан худалдан авахаар төлөвлөж буйг мэдэгдсэн.
 - Энэхүү хэлцэл 2019 оны 4-р сарын 14-нөөс өмнө хийгдэнэ.

2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтэд голлон анхаарч байна. 2019 оны 3-р сард NI 43-101 Урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулахад тэргүүлэн ажиллах байгууллагаар олон улсын инженерчлэлийн байгууллага Tetra-Teck, Inc.-ийг сонгон, хамтран ажиллахаар гэрээ

байгуулсан. Мөн металлургийн шинжилгээг хийлгэхээр Blue Coast Research, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг (“ESIA”) боловсруулахад Sustainability компанитай хамтарч ажиллахаар төлөвлөөд байна. Компани нь Хөндий Алтны Төслийн хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл болгохтой холбоотойгоор Баян Хөндийн тусгай зөвшөөрлийн өргөдөл, шаардлагатай тайлангуудыг тайлагнах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Үүнд: эрдсийн нөөц болон анхан шатны эдийн засгийн тооцооллыг Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яаманд бүртгүүлэх ажлууд багтаж буй бөгөөд 2019 оны 2-р улиралд эцэслэхээр тооцоолж байна.

Эрдэнэ Ресурс нь 4-р сард 2,000 метрийн өрмийн хөтөлбөрийг эхэлнэ, үүний 1,400 метрийг Хөндий Алтны Төсөл дээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү хөтөлбөрийн үр дүнг Tetra-Teck, Inc нь Хөндий Алтны Төслийн Урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулахад ашиглах шинэчилсэн нөөцийн тайланд тусгана. Үлдсэн 600 метрийн хөтөлбөрийг Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын цооног өрөмдөх, өнөөг хүртэл тогтоогдсон алтны эрдэсжилтийг тэлэх болон геотехникийн өрөмдлөг хийхэд зориулна.

Бритиш Колумбын Их Сургуулийн судлаачид нь дараагийн судалгаагаар Эрдэнэ Ресурсийн уурхайн төлөвлөлтийн үе шатанд оролцогч талуудыг оролцуулан, хэрхэн үр ашиг хүртэх боломжтой талаар үргэлжлүүлэн хамтран ажиллах болсон. Түүнээс гадна Компани нь орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих хүрээнд тэтгэлэгт хөтөлбөр, мэргэжлийн сургалт зохион байгуулах, орон нутагт хөгжлийг дэмжих нийлүүлэлтийн гинжин хэлхээг бий болгоход зорин ажиллаж байна.

Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд бүсэд төвлөрсөн хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг боловсруулсан ба энэхүү мэдээллийн санд 22 хэтийн төлөв бүхий талбай багтаж байна. Монгол улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг 2018 оноос эхлэн зарласан бөгөөд Эрдэнэ Ресурс нь 2019 онд дээрх хэтийн төлөв бүхий талбайд зарлагдах тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтанд идэвхтэйгээр оролцоно.

Хөндий алтны төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Энэхүү Төв Азийн Орогены бүс нь БНХАУ-ын нутагт хил дагуу болон бүсийн баруун чиглэлд эпитеpmаль алт болон порфирийн зэс-алтны ордууд сайн судлагдсан байдаг боловч Монгол улсын хувьд 1990-ээд оны дунд үеэс ардчилсан нийгэмд шилжин, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хайгуул хийх боломжийг олгосноор судлагдаж эхэлсэн. Ийнхүү судлагдсанаар дэлхийн хэмжээний алт-зэсийн орд болох Оюу Толгойг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Компани нь одоогоор Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн хайгуул болон нөөцийн хөгжүүлэлтэд 17 сая ам.долларын хөрөнгө зарцуулсан бөгөөд хамтад нь Хөндий Алтны Төсөл хэмээн нэрлэнэ.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 4 хайгуулын, 1 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч танилцах боломжтой. Компанийн тухай тодорхой мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрэх магадлалтай тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш болно. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН
ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН
МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Кэн В. МакДоналд, Дэд ерөнхийлөгч болон Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Емайл: info@erdene.com

Вебсайт: www.erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>